



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/12/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
(Дорноговь аймаг, Сайншанд хот)  
2019 он

Тэргүүлэх аудитор: ..... Ч.Ариунаа  
Утас: 7052-2734      Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn  
Аудитын менежер: .....  
Утас: 7052-3020      Цахим хаяг: .....Ц.Лүндэгмаа  
Аудитор: ..... Л.Баасандорж  
Утас: 9905-5703      Цахим хаяг: baskal88@yahoo.com

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

## АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан .....	3
2.1	Оршил.....	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.11	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.12	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал .....	11
	<b>3.2 БАТЛАГДСАН ТӨСӨВ ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ .....</b>	<b>13</b>
	<b>3.3 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.....</b>	<b>.....</b>
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
	<b>4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН .....</b>	<b>.....</b>
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17

## 1 Аудитын тайлан

### 1.1 Оршил

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Л.Мөнх-Ертөнцөд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018.12.17-наас 2019.02.21-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газраас хариуцаж хэрэгжүүлэв.

Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019.02.12-ны өдрийн 14 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **1.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургууль нь “Өөрийгөө илэрхийлэх чадвартай үндэсний ёс заншлаа дээдэлсэн байгальд ээлтэй бүтээлч иргэнийг төлөвшүүлнэ” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрмээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургууль нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Ерөнхий боловсролын үйлчилгээ
2. Боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлэх
3. Суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй

удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Бага дунд боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Үгүй

#### **1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Аудитын явцад Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

#### **1.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт хөрөнгө*-ын 1 хувиар сонгов.

*Нийт хөрөнгө*-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь аудиторын гүйцэтгэж буй сорил нь хөрөнгийн эрсдэлтэй холбоотой тул нийт хөрөнгийг суурь болгон сонгосонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны *Нийт хөрөнгө* 1,754,859.27 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 17,548.59 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь хөрөнгийн дүнд суурилсан эрсдэл үүсгэх ажил гүйлгээнүүд нь уг дүнгээс доош тохиолдолд аливаа шийдвэр гаргалтад үр нөлөөгүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

#### **1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй

асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	14.8	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	1	71,098.98	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	71,113.08	

**1.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

**2.8.1.1 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт**

Тайлант онд түлш, халаалтын зардал 28,634,500 төгрөг, хоол хүнс 18,372,300 төгрөг, багаж техник хэрэгсэл 13,579,979 төгрөг, урсгал засвар 60,600,000 төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэсэн ба үүнээс урсгал завсарын зардалд зарцуулсан 50,088,500 төгрөгийн худалдан авалтыг холбогдох хуулийн дагуу гүйцэтгэж тайлагнасан ба үлдэх 71,098,979 төгрөгийн худалдан авалтыг холбогдох хуулийн дагуу хийж гүйцэтгээгүй байна.

Энэ нь үнэн зөв байх, оршин байх, бодитой байх зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна ТБОНӨБАҮХАТХ-ийн 8.1.1 дүгээр зүйл “харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, 33.1 дугаар зүйл “Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгч, биелэлтийг 2019 оны 12-р сарын 25-ний дотор Дорноговь аймгийн Төрийн аудитын байгууллагад ирүүлэх, дараа жилийн аудитаар үргэжлүүлэн авч үзэх асуудалд тодорхойлов.

## **ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Цалин хөлсний тооцоолол, тайлагнал  
Төсвийн гүйцэтгэл

### **1.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургууль чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 6 хөтөлбөр, 39 арга хэмжээнд зориулан 2018 онд 436,917.80 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 431,796.78 мянган төгрөг буюу 98.83 хувьтай байгаа нь цалингийн зардал 4,816.3 мян.төгрөгөөр, НДШ-ийн зардал 113.86 мян.төгрөгөөр, тогтмол зардал 7.55 мян.төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 255.92 мян.төгрөгөөр, нормативт зардал 106.17 мян.төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 106.11 мян.төгрөгөөр, томилолт зочны зардал 3.0 мян.төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 32.8 мян.төгрөгөөр, үдийн цай 116.6 мян.төгрөгөөр хэмнэгдэж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 351.49 мян.төгрөгөөр хэтэрснээс шалтгаалжээ.

### **1.10 Шилэн дансны мэдээлэл**

Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **1.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх онд түүвэрт хамрагдсан тул зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **1.12 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил

гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

## **2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1 ХУДАЛДАН АВАЛТ БОЛОН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ, ХЭРЭГЖИЛТ

#### Илрүүлэлт

Тайлант онд түлш, халаалтын зардал 28,634,500 төгрөг, хоол хүнс 18,372,300 төгрөг, багаж техник хэрэгсэл 13,579,979 төгрөг, урсгал засвар 60,600,000 төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэсэн ба үүнээс урсгал завсарын зардалд зарцуулсан 50,088,500 төгрөгийн худалдан авалтыг холбогдох хуулийн дагуу гүйцэтгэж тайлагнасан ба үлдэх 71,098,979 төгрөгийн худалдан авалтыг холбогдох хуулийн дагуу хийж гүйцэтгээгүй байна.

Энэ нь ТБОНӨБАҮХАТХ-ийн 8.1.1 дүгээр зүйл “харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, 33.1 дугаар зүйл “Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

#### Эрсдэл

Холбогдох хуулийг хэрэгжүүлээгүйгээс хуулийн хариуцлага хүлээх, ашиг сонирхлын зөрчил үүсэх

#### Зөвлөмж

Тайлант оны худалдан авалтыг хэрэгжүүлэхдээ ТБОНӨХБАҮХАТХ-ийг хэрэгжүүлж ажиллах

#### Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Мөнх-Ертөнц

#### Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлж ажиллана

Үйлчлүүлэгч хариуг 2019.02.21-нд бичгээр ирүүлсэн болно.

### 3.2 ТУХАЙН БАЙГУУЛЛАГА, САЛБАРТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

#### Илрүүлэлт

Ажилчин О.Болортуяа, Б.Гантуяа нарын ХЧАТ-ээс 14803 төгрөгийн ХХОАТ суутгасан байна.

Энэ нь үнэн зөв байх, бодитой байх зэрэг батламж мэдэгдэлд нийцэхгүйгээс гадна ХХОАТ-ийн тухай хуулийн 16.1."Дараахь орлогыг албан татвараас чөлөөлнө" 16.1.1 "хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөх олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж" Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 29-р заалт "Тэтгэвэр, тэтгэмжээс суутгал хийх", 29.4. "Энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд тэтгэвэр, тэтгэмжээс суутгал хийхийг хориглоно" гэсэн заалтуудтай зөрчилдөж байна.

#### Эрсдэл

Холбогдох хуулийн буруу хэрэгжүүлснээс хувь хүнд хохирол учруулах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

#### Зөвлөмж

ХХОАТ-ийн тухай хуулийн 16.1.1 болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 29-р заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

#### Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Мөнх-Ертөнц

#### Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийн хэрэгжүүлж ажиллана.

Үйлчлүүлэгч хариуг 2019.02.21-нд бичгээр ирүүлсэн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 12-р сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### **АУДИТЫН ТАЙЛАНГ**

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ч.АРИУНАА

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Ц.ЛҮНДЭГМАА

БЭЛТГЭСЭН: АУДИТОР:

Л.БААСАНДОРЖ

### 3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

#### 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>62,281,045.20</b>	<b>76,805,711.20</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	32.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	32.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	32.00
<b>31215</b>	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	32.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	891,000.00	81,000.00
<b>33100</b>	Ажиллагчидтай холбогдсон авлага	891,000.00	81,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	61,390,045.20	76,724,679.20
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	16,931,332.00	26,246,332.00
<b>35110</b>	Тусгай зориулалттай материал	16,931,332.00	26,246,332.00
<b>35300</b>	Бэлэн бүтээгдэхүүн	7,200.00	4,200.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	44,451,513.20	50,474,147.20
<b>35410</b>	Бичиг хэргийн материал	134,000.00	24,000.00
<b>35420</b>	Аж ахуйн материал	21,920,710.20	23,801,079.20
<b>35440</b>	Түлш, шатах тослох материал	10,237,850.00	13,969,000.00
<b>35460</b>	Хүнсний материал	8,840,855.00	7,880,770.00
<b>35470</b>	Бусад хангамжийн материал	3,318,098.00	4,799,298.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,184,424,903.60</b>	<b>938,835,753.90</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,184,424,903.60	938,835,753.90
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,184,424,903.60	922,385,753.90
<b>39201</b>	Барилга, байгууламж, орон сууц	1,826,785,795.00	911,847,430.00
<b>39202</b>	Хуримтлагдсан элэгдэл	-725,321,857.56	-70,430,483.47
<b>39205</b>	Машин тоног төхөөрөмж (компьютер)	76,609,462.11	97,856,425.11
<b>39206</b>	Хуримтлагдсан элэгдэл	-31,619,370.93	-57,774,464.46
<b>39207</b>	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,375,651.20	56,919,648.20
<b>39208</b>	Хуримтлагдсан элэгдэл	-48,780,224.72	-36,818,680.18
<b>39214</b>	Бусад үндсэн хөрөнгө	24,726,200.00	24,726,200.00
<b>39215</b>	Хуримтлагдсан элэгдэл	-2,029,836.36	-9,426,806.16
<b>39217</b>	Ном	4,679,084.86	5,486,484.86
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	00.00	16,450,000.00
<b>39301</b>	Програм хангамж	110,000.00	110,000.00
<b>39302</b>	Хуримтлагдсан элэгдэл	-110,000.00	-110,000.00
<b>39303</b>	Бусад биет бус хөрөнгө	00.00	16,450,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,246,705,948.80</b>	<b>1,015,641,465.10</b>
<b>4</b>	<b>НИЙТ ОР ТӨЛБӨР</b>	<b>1,782,000.00</b>	<b>1,319,980.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ОР ТӨЛБӨР</b>	1,782,000.00	1,319,980.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,782,000.00	1,319,980.00
<b>41310</b>	Ажилчидтай холбогдсон өглөг	1,782,000.00	1,301,980.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.00	18,000.00
<b>41361</b>	Байгууллагад төлөх өглөг	00.00	18,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,244,923,948.80</b>	<b>1,014,321,485.10</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,244,923,948.80	1,014,321,485.10
<b>511</b>	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	736,656,201.20	753,106,201.20
<b>51101</b>	Өмч: - төрийн	736,656,201.20	753,106,201.20
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-280,401,543.80	-570,072,272.22
<b>51210</b>	Өмнөх үеийн үр дүн	-280,401,543.80	-230,501,543.80
<b>51220</b>	Тайлант үеийн үр дүн	00.00	-339,570,728.42
<b>51300</b>	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	788,669,291.40	831,287,556.12
<b>6</b>	<b>ОР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,246,705,948.80</b>	<b>1,015,641,465.10</b>

#### 3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>244,471,040.00</b>	<b>455,720,239.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>57,204,100.00</b>

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

120	Нийтлэг татварын бус орлого	00.00	57,204,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	57,204,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	57,204,100.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>244,471,040.00</b>	<b>398,516,139.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	244,083,800.00	398,516,139.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	244,083,800.00	398,516,139.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	387,240.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	387,240.00	00.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>184,394,300.40</b>	<b>432,194,833.39</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>184,394,300.40</b>	<b>432,194,833.39</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	173,662,100.40	413,162,359.39
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	115,621,552.00	213,866,140.00
210101	Үндсэн цалин	87,703,270.00	147,419,600.00
210102	Нэмэгдэл	23,620,037.00	44,570,060.00
210104	Урамшуулал	4,298,245.00	21,876,480.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,669,300.00	27,627,500.00
210201	Тэтгэврийн даатгал	8,698,647.00	18,994,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,212,948.00	2,151,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,023,844.00	1,733,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	248,533.00	431,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,485,328.00	4,316,500.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,535,295.00	27,789,156.00
210301	Гэрэл, цахилгаан	1,586,295.00	2,940,581.00
210302	Түлш, халаалт	7,949,000.00	24,142,500.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	706,075.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,972,927.00	7,496,441.00
210401	Бичиг хэрэг	667,560.00	2,247,700.00
210402	Тээвэр, шатахуун	347,400.00	2,459,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	69,407.00	555,091.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,000.00	370,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	858,560.00	1,863,850.00
2105	<b>Нормативт зардал</b>	11,392,890.00	19,849,655.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,150.00	307,250.00
210502	Хоол, хүнс	11,334,740.00	19,542,405.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	61,644,107.00
210604	Урсгал засвар	00.00	61,644,107.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	116,000.00	820,000.00
210702	Дотоод албан томилолт	116,000.00	820,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	160,000.00	586,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,000.00	586,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	21,194,136.40	53,483,360.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	95,000.00	1,174,720.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	172,000.00	173,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,927,136.40	52,135,640.39
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	10,732,200.00	19,032,474.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10,732,200.00	17,397,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,778,800.00	7,481,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,953,400.00	9,916,200.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	1,634,874.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,634,874.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>60,076,739.60</b>	<b>23,525,405.61</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	363,096,134.03
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	363,096,134.03
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-363,096,134.03
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>60,076,739.60</b>	<b>-339,570,728.42</b>

**3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>244,471,040.00</b>	<b>398,516,139.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>244,471,040.00</b>	<b>398,516,139.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	244,083,800.00	398,516,139.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	244,083,800.00	398,516,139.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	387,240.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	387,240.00	00.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>157,504,324.00</b>	<b>390,198,347.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>157,504,324.00</b>	<b>390,198,347.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>146,781,724.00</b>	<b>371,104,353.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	115,621,552.00	213,536,160.00
210101	Үндсэн цалин	87,703,270.00	147,419,600.00
210102	Нэмэгдэл	23,620,037.00	44,570,060.00
210104	Урамшуулал	4,298,245.00	21,546,500.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,669,300.00	27,627,500.00
210201	Тэтгэврийн даатгал	8,698,647.00	18,994,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,276,555.00	2,151,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	960,237.00	1,733,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	248,533.00	431,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,485,328.00	4,316,500.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8,569,795.00	32,281,156.00
210301	Гэрэл, цахилгаан	1,586,295.00	2,940,581.00
210302	Түлш, халаалт	6,950,000.00	28,634,500.00
210303	Цэвэр, бохир ус	33,500.00	706,075.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,004,717.00	3,707,141.00
210401	Бичиг хэрэг	111,390.00	436,500.00
210402	Тээвэр, шатахуун	347,400.00	1,698,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	202,227.00	707,791.00
210404	Ном, хэвлэл	00.00	134,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,000.00	370,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	313,700.00	359,700.00
2105	<b>Нормативт зардал</b>	6,297,760.00	19,481,350.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	89,700.00	359,250.00
210502	Хоол, хүнс	6,191,260.00	18,372,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,800.00	749,800.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	265,200.00	68,472,226.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	7,180,619.00
210604	Урсгал засвар	265,200.00	61,291,607.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	116,000.00	820,000.00
210702	Дотоод албан томилолт	116,000.00	820,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	160,000.00	644,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,000.00	644,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,077,400.00	4,534,820.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	95,000.00	1,174,720.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	982,400.00	3,360,100.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,722,600.00</b>	<b>19,093,994.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10,722,600.00	17,459,120.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,769,200.00	7,542,920.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,953,400.00	9,916,200.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	1,634,874.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,634,874.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>86,966,716.00</b>	<b>8,317,792.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>66,000.00</b>	<b>8,317,760.00</b>

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>66,000.00</b>	<b>8,317,760.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	66,000.00	8,317,760.00
<b>225106</b>	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	66,000.00	8,317,760.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-66,000.00</b>	<b>-8,317,760.00</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	86,900,716.00	32.00
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	86,900,716.00	32.00

**3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан**

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	736,656,201.20	788,669,291.40	-527,471,220.15	997,854,272.45
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>736,656,201.20</b>	<b>788,669,291.40</b>	<b>-527,471,220.15</b>	997,854,272.45
<b>Тайлант үеийн үр дүн</b>	00.00	00.00	60,076,739.60	60,076,739.60
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>736,656,201.20</b>	<b>788,669,291.40</b>	<b>-280,401,543.80</b>	1,244,923,948.80
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>736,656,201.20</b>	<b>788,669,291.40</b>	<b>-280,401,543.80</b>	1,244,923,948.80
<b>Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт</b>	00.00	00.00	49,900,000.00	49,900,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>736,656,201.20</b>	<b>788,669,291.40</b>	<b>-230,501,543.80</b>	1,294,823,948.80
<b>Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт</b>	00.00	42,618,264.72	00.00	42,618,264.72
<b>Тайлант үеийн үр дүн</b>	16,450,000.00	00.00	-339,570,728.42	-323,120,728.42
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>753,106,201.20</b>	<b>831,287,556.12</b>	<b>-570,072,272.22</b>	1,014,321,485.10

**3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

ЭЗ-ийн ангиал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	396,152,000.00	394,517,126.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	396,152,000.00	394,517,126.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	377,296,700.00	377,058,006.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	213,629,100.00	213,536,160.00
<b>210101</b>	Үндсэн цалин	147,419,600.00	147,419,600.00
<b>210102</b>	Нэмэгдэл	44,618,000.00	44,570,060.00
<b>210104</b>	Урамшуулал	21,591,500.00	21,546,500.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,627,500.00	27,627,500.00
<b>210201</b>	Тэтгэврийн даатгал	18,994,300.00	18,994,300.00
<b>210202</b>	Тэтгэмжийн даатгал	2,151,700.00	2,151,700.00
<b>210203</b>	ҮОМШӨ-ний даатгал	1,733,400.00	1,733,400.00
<b>210204</b>	Ажилгүйдлийн даатгал	431,600.00	431,600.00
<b>210205</b>	Эрүүл мэндийн даатгал	4,316,500.00	4,316,500.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,281,500.00	32,281,156.00
<b>210301</b>	Гэрэл, цахилгаан	3,497,500.00	2,940,581.00
<b>210302</b>	Түлш, халаалт	28,134,000.00	28,634,500.00
<b>210303</b>	Цэвэр, бохир ус	650,000.00	706,075.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,046,200.00	3,921,041.00
<b>210401</b>	Бичиг хэрэг	484,500.00	436,500.00
<b>210402</b>	Тээвэр, шатахуун	1,700,000.00	1,698,950.00
<b>210403</b>	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	686,000.00	707,791.00
<b>210404</b>	Ном, хэвлэл	406,000.00	348,100.00
<b>210405</b>	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	410,000.00	370,000.00
<b>210406</b>	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	359,700.00	359,700.00
2105	<b>Нормативт зардал</b>	19,482,300.00	19,481,350.00
<b>210501</b>	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	360,000.00	359,250.00

Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>210502</b>	Хоол, хүнс	18,372,300.00	18,372,300.00
<b>210503</b>	Нормын хувцас, зөөлөн эдлэл	750,000.00	749,800.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	74,180,000.00	74,179,979.00
<b>210601</b>	Багаж, техник, хэрэгсэл	13,580,000.00	13,579,979.00
<b>210604</b>	Урсгал засвар	60,600,000.00	60,600,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	788,700.00	820,000.00
<b>210702</b>	Дотоод албан томилолт	788,700.00	820,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	806,000.00	806,000.00
<b>210801</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	806,000.00	806,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4455400.00	4404820.00
<b>210901</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	1,140,000.00	1,174,720.00
<b>210902</b>	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,315,400.00	3,230,100.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	18855300.00	17459120.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	18,855,300.00	17,459,120.00
<b>213205</b>	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,939,100.00	7,542,920.00
<b>213208</b>	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,916,200.00	9,916,200.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	396,152,000.00	396,152,000.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	396,152,000.00	396,152,000.00
<b>131001</b>	Улсын төсвөөс санхүүжих	396,152,000.00	396,152,000.00